

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын  
даргын 2018 оны 12 дугаар сарын 26-ны  
өдрийн 72 дугаар захирамжийн хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Залуучуудыг ажил хөдөлмөр, бүтээлч үйлдвэрлэл, шинжлэх ухаанч хөгжилд уриалах, залуу үеийн мэргэжлийн боловсрол, ур чадвар, мэргэшсэн боловсон хүчний бодлогыг дэмжих зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал (цаашид “Нэрэмжит шагнал” гэх) олгоход энэхүү журмыг баримтална.

### Хоёр. Нэрэмжит шагнал

2.1. Нэрэмжит шагналаар мэргэжлийн ур чадвар, ажлын бүтээмжээрээ өөрийн ажиллаж буй салбартаа онцгой амжилт гарган тэргүүлж, үлгэр жишээ хувь нэмэр оруулсан 35 хүртэлх насны Монгол Улсын иргэнийг шагнана.

2.2. Нэрэмжит шагнал нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналын батламж, 5,000,000.0 (таван сая) төгрөгийн дагалдах мөнгөн урамшуулал байх бөгөөд энэхүү журамд заасан хугацаанд Төрийн ордонд гардуулна.

2.3. Уг шагналыг хүртсэн иргэнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт медаль” хүртээж болох бөгөөд үүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.

### Гурав. Нэрэмжит шагналын төрөл, гардуулах хугацаа

3.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал нь дараах төрөлтэй байх бөгөөд заасан хугацаанд гардуулна. Үүнд:

3.1.1. Шилдэг залуу эрдэмтэн – Жил бүрийн 11 дүгээр сарын 4 дэх долоо хоногийн ням гарагт болдог Шинжлэх ухааны ажилтны өдрийг тохиолдуулан;

3.1.2. Шилдэг залуу эмч - Жил бүрийн 8 дугаар сарын хоёр дахь ням гарагт болдог Эрүүл мэндийн салбарын ажилтны өдрийг тохиолдуулан;

- 3.1.3. Шилдэг залуу ажилчин - Жил бүрийн 3 дугаар сарын 26-нд болдог Хөнгөн хүнсний аж үйлдвэрийн ажилтан, ажилчдын өдрийг тохиолдуулан.
- 3.1.4. Бусад шилдэг залуу мэргэжилтэн - Жил бүрийн 12 дугаар сарын 29-нд болдог Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдрийг тохиолдуулан тус тус гардуулна.
- 3.2 Нэрэмжит шагнал тус бүрийг жилд 3 хүртэл хүнд хүртээж болно.

### **Дөрөв. Нэр дэвшүүлэх, шалгаруулах**

- 4.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналд тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн холбоо, академи, төрийн бус байгууллагууд нэр дэвшүүлж, нэр дэвшигчийн бичиг баримтыг энэхүү журмын 3.1 дэх хэсэгт заасан шагнал гардуулах хугацаанаас 30 хоногийн өмнө Ерөнхийлөгчийн Тамгын газарт ирүүлнэ.
- 4.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар өөрийн санаачилгаар шагналд нэр дэвшүүлж болно. Энэ тохиолдолд холбогдох баримт бичгийг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлнэ.
- 4.3. Нэр дэвшигчийн гаргасан амжилт, ажлын үр дүн, шинэ санаа, дүгнэлт, тухайн салбартаа оруулсан хувь нэмэр нь товч тодорхой, тооцоо, баримтаар нотлогдсон байна.
- 4.4. Нэр дэвшигчийн бичиг баримт нь үнэн зөв бөгөөд баталгаажсан, нэр дэвшүүлсэн газрын хурлаар хэлэлцсэн байна.
- 4.5. Нэр дэвшигчдийн баримт бичиг, материалыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нягтлан судална.
- 4.6. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд төрийн байгууллага, мэргэжлийн холбоо шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэн судлаач, иргэд олон нийтийн төлөөллийг оруулж болно.
- 4.7. Ажлын хэсэг бүрдүүлбэл зохих баримт бичгүүдийг хянаж, энэ журмын шаардлагад нийцсэн нэр дэвшигчийн талаар санал боловсруулан Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулна.
- 4.8. Баримт бичгийн бүрдэл дутуу, журамд заасан хугацаанаас хожимдуулж ирүүлсэн материалыг шалгаруулалтад оруулахгүйгээр нэр дэвшүүлсэн газарт буцаана.
- 4.9. Монгол Улсын Ерөнхийлөгч шагналд нэр дэвшигчдийн талаарх Тамгын газрын саналтай танилцаад Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал олгох тухай Зарлиг гаргана.
- 4.10. Нэрэмжит шагнал хүртсэн нэр дэвшигчийн тодорхойлолт, холбогдох бусад баримт бичгийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын архивд хадгална.

## Тав. Бүрдүүлэх бичиг баримт

5.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт дараах бичиг баримтыг ирүүлнэ. Үүнд:

- 5.1.1. Шагналд нэр дэвшүүлэх тухай эрх бүхий байгууллагын санал, шийдвэр, хурлын тэмдэглэл;
- 5.1.2. Нэр дэвшигчийн ажлын үзүүлэлт, гаргасан амжилтын талаарх товч танилцуулга (1-2 нүүр);
- 5.1.3. Шагналд нэр дэвшүүлж буй хүний ажлын үзүүлэлтэд төрийн байгууллага, мэргэжлийн холбоо, мэргэжилтнээс гаргасан 2 шүүмж, дүгнэлт;
- 5.1.4. Бүтээл туршлага нь хэрэглээ, үйлдвэрлэлд нэвтэрсэн бол тухайн үйлдвэр, аж ахуйн нэгжийн тодорхойлолт;
- 5.1.5. Нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт;
- 5.1.6. Нэр дэвшигчийн мэдүүлэг (Төрийн албан хаагчийн анкетын 1 дүгээр маягт);
- 5.1.7. Нэр дэвшигчийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан буюу танилцуулсан материалууд ирүүлж болно.

----- оОо -----